

**“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 26 өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн дүрэм шинэчлэн батлах,  
дүрмийн санг нэмэгдүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 31, 62 дугаар зүйл болон хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК (цаашид “компани” гэх) нь нийт энгийн хувьцааныхаа 30 хувьтай тэнцэх 122,655,128 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр олон нийтэд амжилттай арилжаалж, нээлттэй хувьцаат компани болсныг дурьдсугай.
2. Компанийн дүрмийн сангийн хэмжээг 695,454,575.76 төгрөгөөр нэмэгдүүлж нийт дүрмийн сангийн хэмжээг 2,318,181,926.76 /хоёр тэрбум гурван зуун арван найман сая нэг зуун наян нэгэн мянга есөн зуун хорин зургаан төгрөг далан зургаан мөнгө/ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болсныг баталгаажуулсугай.
3. “Монос хүнс Хувьцаат компанийн дүрэм”-ийг энэхүү тогтоолын Хавсралт №01-ээр баталсугай.
4. Шинэчилсэн дүрмийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт бүртгүүлэх, батлагдсан дүрмийн хуулбарыг Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлж ажиллахыг ҮАХ Захирал (П.Тодрол)-д үүрэг болгосугай.
5. Дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



П.ТОДРОЛ

**“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 26 өдөр

№ 02

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС  
ХУРЛЫН ТОГТООЛ**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
Гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг болон хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 03 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК (цаашид “компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасан бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах 2019 оны зардлын төсвийг Хавсралт №02-д зааснаар баталсугай.
3. Компанийн дүрэм, хууль тогтоомж, дотоод үйл ажиллагааны журам зэрэг компанийн засаглалын тогтолцооны холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Шинээр томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат гишүүдийн талаархи мэдээллийг Хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид мэдэгдэхийг ҮАХ Захирал (П.Тодрол)-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



П.ТОДРОЛ

2019 оны 06 сарын 26 өдрийн ХЭЭБХ-ын  
02 тоот тогтоолын хавсралт №01

УЛААНБААТАР ХОТ  
МОНОС ХҮНС  
ХХК  
915 5568927

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

**1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүд:**

- 1.1. Лувсангийн Хүрэлбаатар
- 1.2. Хүрэлбаатарын Ананд
- 1.3. Хүрэлбаатарын Солонго
- 1.4. Цэдэндамбын Цэцэгбадам
- 1.5. Агваандоржийн Отгондарь
- 1.6. Чимэддоржийн Баттогтох

**2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүд:**

- 2.1. Булганы Гантулга
- 2.2. Бөхбатын Долормаа
- 2.3. Чулууны Чинзориг

2019 оны 06 сарын 26 өдрийн ХЭЭБХ-ын  
02 тоот тогтоолын хавсралт №02



**Монос Хүнс ХК ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв**

| Гишүүд                                      | Орон тоо | Улирал тутмын цалин | Тоо хэмжээ | Нийт                 |
|---|----------|---------------------|------------|----------------------|
| ТУЗ-ийн дарга                               | 1        | 1,200,000.00        | 4          | 4,800,000.00         |
| Цалин, Урамшуулал, стратегийн хорооны дарга | 1        | 1,000,000.00        | 4          | 4,000,000.00         |
| Аудитийн хороон дарга                       | 1        | 1,000,000.00        | 4          | 4,000,000.00         |
| Нэр дэвшүүлэлтийн хороон дарга              | 1        | 1,000,000.00        | 4          | 4,000,000.00         |
| Гишүүн                                      | 1        | 500,000.00          | 4          | 2,000,000.00         |
| Гишүүн                                      | 1        | 500,000.00          | 4          | 2,000,000.00         |
| Гишүүн                                      | 1        | 500,000.00          | 4          | 2,000,000.00         |
| Гишүүн                                      | 1        | 500,000.00          | 4          | 2,000,000.00         |
| Гишүүн                                      | 1        | 500,000.00          | 4          | 2,000,000.00         |
| Нарийн бичгийн дарга                        | 1        | 500,000.00          | 12         | 6,000,000.00         |
| <b>Нийт</b>                                 |          |                     |            | <b>32,800,000.00</b> |

| Бичиг хэрэг албан зардлууд | Жил тутмын зардал | Улирал тутмын зардал | Тоо хэмжээ | Нийт                |
|----------------------------|-------------------|----------------------|------------|---------------------|
| Хувьцаа эзэмшигчдийн хурал | 7,000,000.00      |                      | 1          | 7,000,000.00        |
| ТУЗ-ийн хурал              |                   | 400,000.00           | 4          | 1,600,000.00        |
| Бичиг хэрэг бусад зардал   |                   |                      |            | 500,000.00          |
| <b>Нийт</b>                |                   |                      |            | <b>9,100,000.00</b> |

ТУЗ-ийн нийт зардлын төсөв

|             |                      |
|-------------|----------------------|
| Цалин       | 32,800,000.00        |
| Бусад       | 9,100,000.00         |
| <b>НИЙТ</b> | <b>41,900,000.00</b> |